

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа I-IV улирал/	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /биелээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хэрэгцээг хангахуйц, чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.								
Зорилт 1. Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.								
1.1	Ерөнхий мэс засал, эмэгтэйчүүд, урологи, хавдар, булчирхайн мэс заслын дурангийн хагалгаануудад роботик мэс залыг нэвтрүүлж, нутагшуулна.	МОН-8 төсөл	Амжилттай хийсэн роботик мэс заслын тоо	Роботик мэс засал нэвтрээгүй.	Ерөнхий мэс засал, эмэгтэйчүүд, урологи, хавдар, булчирхайн мэс заслын дурангийн хагалгаануудад роботик мэс залыг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Төсөл бичиж ЭМЯ ба СЯ-д танилцуулсан боловч шийдэгдээгүй байна.	0%
1.2	Өвдөгний үений эмгэг судасжилтыг бөглөх мэс заслыг нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийсэн өвдөгний үений мэс заслын тоо	2022 онд 34 өвчтөнд туршилтын байдлаар мэс засал хийсэн.	2023 онд хагалгаанд орох заалттай өвчтөнүүдэд өвдөгний үений эмгэг судасжилтыг бөглөх мэс заслыг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	2023 онд остеоартриттай хүнд өвдөгний үений эмгэг судасжилт бөглөх мэс ажилбарыг нэвтрүүлж одоогоор 35 хүнд мэс ажилбарыг амжилттай хийж 1,3,6 сар,1 жил гэсэн давтамжаар хяналт хийхэд хүндрэл илрээгүй.	100%
1.3	Меньерийн өвчин, Байршлын хамааралт толгой эргэлт, тэнцвэрийн мэдрэлийн үрэвсэл зэрэг 3 эмгэгийг эмчлэх Sacculotomy мэс заслыг нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийсэн Sacculotomy мэс заслын тоо	Одоогоор нэвтрээгүй.	2023 онд хагалгаанд орох заалттай өвчтөнүүдэд Sacculotomy мэс заслыг амжилттай хийсэн байна.	I-IV улирал	Шаардлагатай багажны захиалга хийгдсэн.Нийлүүлэлт хийгдээгүй байгаа тул одоогоор хийгдээгүй байна.	0%
1.4	Хиймэл оюун ухааны программыг оношилгоонд нэвтрүүлнэ.	-	Хиймэл оюун ухааны программыг ашиглан оношилгоо хийсэн хүний тоо	Одоогоор нэвтрээгүй. Программ суугдаагүй.	Программ суугдаагүй	I-IV улирал	Программ нэвтрээгүй байгаа ба судалгааны түвшинд явж байна.	0%
Зорилт 2. Оношилгоо, эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээг орчин үеийн нотолгоонд суурилсан анагаах ухааны хөгжлийн түвшинд үзүүлэх								
2.1	ПЭТ/КТ (РЕТ/СТ) оношилгоонд ашиглаж буй цацраг идэвхит эмийн нэр төрлийг нэмэгдүүлнэ.	-	NaF цацраг идэвхит эмийг ашиглан оношилгоо хийлгэсэн хүний тоо	NaF /фторт натри/ эмийг Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагаа эхэлсэн.	NaF /фторт натри/ ашиглан ПЭТ/КТ (РЕТ/СТ) оношилгоо 20-с доошгүй хүнд хийсэн байна.	I-IV улирал	NaF /фторт натри/ эмийг Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгүүлж Эмийн бүртгэлийн L20230914VN08589 дугаартай тарилгын уусмалын 0023243 бүртгэлийн гэрчилгээ авч ЭМЯ-ны Licemed цахим хуудаст байршуулсан. Эмнэлзүйн практикт 11 дүгээр сарын хагасаас нэвтрүүлнэ.	100%

2.2	ФДГ Цацраг идэвхит эмийг ашиглан ПЭТ/КТ оношилгооны тоог нэмэгдүүлнэ.	-	ФДГ цацраг идэвхит эмийг ашиглан оношилгоо хийлгэсэн хүний тоо	2022 онд ФДГ цацраг идэвхит эм ашиглан 646 хүнд (PET/CT) оношилгоо хийсэн.	Цацраг идэвхт эм ашиглан оношилгоог (PET/CT) 700-с доошгүй хүнд хийсэн байна.	I-IV улирал	2023 оны эхний 10 сард нийт 610 хүнд ФДГ болон ПЭТ/КТ хийсэн байна.	100%
2.3	Ясны сийрэгжилтийн оношилгооны тоог нэмэгдүүлнэ.	-	Ясны сийрэгжилтийн оношилгоо хийсэн хүний тоо	2022 онд ясны сийрэгжилтийн оношилгоог 100 хүнд хийсэн.	Ясны сийрэгжилтийн оношилгоог 500-с доошгүй хүнд хийсэн байна.	I-IV улирал	Нийт 1313 ясны сийрэгжилт эхний 10 сард хийгдсэн.	100%
2.4	ФДГ цацраг идэвхит эмийн үйлдвэрлэлийн тоог нэмэгдүүлнэ.	-	Үйлдвэрлэсэн цацраг идэвхит эмийн тоо	2022 онд 111 үйлдвэрлэл хийсэн.	140-с доошгүй ФДГ цацраг идэвхт эмийг үйлдвэрлэсэн байна.	I-IV улирал	18Ф-ФДГ цацраг идэвхт эмийн үйлдвэрлэл эхний 10 сард нийт 107 удаа хийгдсэн. Үйлдвэрийн тоо цөөн хэдийч ФДГ-ПЭТ/КТ шинжилгээнд орсон болон эм борлуулсан хүн/тунгийн тоо их байгаа нь бага зардлаар үр ашигтай ажиллах зарчмыг баримталж байна.	100%
2.5	ФДГ цацраг идэвхит эмийн борлуулалтыг нэмэгдүүлнэ.	-	Борлуулсан цацраг идэвхит эмийн тоо	2022 онд 157 хүн/тун цацраг идэвхт эм борлуулсан.	300-с доошгүй хүн/тун цацраг идэвхит эмийг борлуулсан байна.	I-IV улирал	Эхний 10 сарын байдлаар 507 хүн/тун цацраг идэвхт эмийг борлуулсан.	100%
2.6	Йод-131 цацраг идэвхит эмийн бодисоор бамбайн булчирхайн хавдар, бамбайн хордлогыг эмчилнэ.	-	Эмчилгээ хийлгэсэн хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлж эхлэсэн байна.	I-IV улирал	Йод-131 эмчилгээг бамбай булчирхайн хорт хавдар болон бамбайн булчирхайн хордлогот бахуун эмчилгээнд 2023 оны 6 дугаар сараас нэвтрүүлж үйл ажиллагааг тогтворжуулсан.	100%
2.7	Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын баталгаа гэрчилгээ авах үйл явцыг эхлүүлнэ. /GMP стандарт/	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Үндсэн шаардлагын дагуу бичиг баримтын боловсруулалт болон дата цуглуулж байна.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	I-IV улирал	Үйл ажиллагааг эхлүүлж Эм үйлдвэрлэлтийн зохистой дадлын шаардлагыг хангах 164 шалгуур үзүүлэлтээс эхний 10 сарын байдлаар 86%-ийн биелэлттэй явж байгааг ЭЭХХЗГ-ын байцаагч нарын шалгалтаар үнэлэгдсэн. 11 дүгээр сарын 30-нд GMP батламж авах албан хүсэлт ЭЭХХЗГ-т хүргүүлэхээр төлөвлөж байна. УХТЭ-ийн Ерөнхий захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	100%
2.8	Дэвшилтэт технологид суурилсан, хавдрын дүрс оношилгооны төрлийг нэмэгдүүлнэ.	-	Шинээр нэвтрүүлсэн тоног төхөөрөмж ашиглан оношилгоо хийсэн хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	MRI спектроскопи Тархины перфузи Трактографи Хэвлий болон бага аарцгийн перфузи Зүрх, том судасны компьютерт томографийн оношилгоог тогтмол хийдэг болсон байна.	I-IV улирал	Тархины MRI спектроскопи, перфузи,трактографи шинжилгээ хийгдэж байна.	100%

2.9	Голомтот эмгэгүүдийг дүрс оношилгооны хэт авиа, Компьютерт томографи, MRI шинжилгээгээр тодорхойлох, ангилах LI-RADS стандарт удирдамжийг нэвтрүүлнэ.	-	Эрт үед оношлогдсон хавдартай хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Голомтот эмгэгүүдийг дүрс оношилгооны хэт авиа, Компьютерт томографи, MRI шинжилгээгээр тодорхойлох, ангилах LI-RADS стандарт удирдамжийг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	LI-RADS удирдамжийг монгол хэл рүү хөрвүүлж ЭМЯ-ны Дүрс оношилгооны мэргэжлийн салбар зөвлөлд хүлээлгэн өгсөн.	100%
2.1	Элэг цэсний голомтот эмгэгүүдийн оношилгоонд элэг цэсний өвөрмөц тодосгогч бодистой соронзон резонанст томографи шинжилгээг нэвтрүүлнэ.	-	Эрт үед оношлогдсон хавдартай хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Элэг цэсний өвөрмөц тодосгогч бодистой соронзон резонанст томографи шинжилгээг амжилттай нэвтрүүлсэн байна. Хавдрыг эрт үед оношилж тоог нэмэгдүүлсэн байна.	I-IV улирал	Элэг цэсний өвөрмөц тодосгогч бодисыг 2024 оны тендерийн захиалгад оруулсан. Мөн MRI аппаратны автомат инжекторын баттерейг захиалсан.	100%
2.11	Хэт авиан эластографи болон Компьютер томографийн шинжилгээтэй бодит агшинд нэгтгэж (fusion) харьцуулах технологийг нэвтрүүлнэ.	-	Элэгний хатуурлын зэргийг тодорхойлох шинжилгээнд орсон хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Хэт авиан эластографи болон Компьютер томографийн шинжилгээтэй бодит агшинд нэгтгэж (fusion) харьцуулах технологийг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Одоогоор хийгдээгүй.	0%
2.12	Үе солих хагалгаа болон үений дурангийн хагалгааны тоог нэмэгдүүлнэ.	-	Амжилттай хийсэн хагалгааны тоо	2022 онд өвдөгний үе солих 100, түнхний үе солих 10 хагалгаа, үений дурангийн 25 хагалгааг төсөвт багтааж хийсэн.	Өвдөгний үе солих хагалгаа 200, түнхний үе солих хагалгаа 50, үений дурангийн хагалгааг 50-с дээш тохиолдолд амжилттай хийсэн байна.	I-IV улирал	2023-1 сараас 11 сарын 17-ны хооронд өвдөгний үе солих 185, түнхний үе бүтэн солих 18, түнхний үе хагас солих 9 хагалгаа, өвдөгний үений дурангийн 21 хагалгаа хийгдсэн байна.	100%
2.13	Түнхний үе солих хагалгаанд Navigation ашиглана.	-	Амжилттай хийсэн хагалгааны тоо	2022 онд Түнхний үе солих хагалгаанд Navigation ашиглахаар төлөвлөсөн боловч хийгдэж чадаагүй.	Түнхний үе солих хагалгаанд Navigation ашиглаж 10-с дээш хагалгаа хийсэн байна.	I-IV улирал	Түнхний үе солих Navigation хагалгаа эхлүүлэх зорилгоор УХТЭ-ийн эмч Б.Батзориг, Г.Билгүүн нар Япон улсад сургалтад явсан ба хүнээ сургаж бэлтгэл хийгдэж байна. Уг хагалгаанд хэрэглэгдэх багаж, программын асуудал шийдэгдээгүй тул хагалгаа хийгдээгүй байна.	30%

2.14	Зүрхний төрөлхийн болон олдмол гажгийг судсан дотуурх аргаар эмчлэх мэс ажилбарын тоог нэмэгдүүлнэ.	-	Амжилттай хийсэн мэс ажилбарын тоо	Зүрхний тосгуур хоорондын таславчийн төрөлхийн цоорхойг судсан дотуурх мэс заслаар бөглөх /шүхрээр/ ажилбарыг УХТЭ-д 2022.10.12-д амжилттай хийсэн тохиолдол 1 ба цаашид тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	Зүрхний төрөлхийн болон олдмол гажгийг судсан дотуурх мэс ажилбарыг 10 хүнд амжилттай хийсэн байна.	I-IV улирал	2023 онд өндөр өртөгт эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга хийгдсэн тоог нэмэгдүүлээгүй байна.	20%
2.15	Зүрхний гэнэтийн нас баралтаас сэргийлэх /ICD/, зүрхний архаг дутагдлын үеийн CRT суулгац эмчилгээг шинээр нэвтрүүлнэ.	-	Суулгац эмчилгээг амжилттай хийсэн хүний тоо	Одоогоор нэвтрээгүй.	Зүрхний гэнэтийн нас баралтаас сэргийлэх /ICD/ болон зүрхний архаг дутагдлын үеийн 2 ховдолд пейсмейкер суулгах CRT суулгац эмчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Суулгацын захиалга хийгдсэн өндөр өртөгт эм, эмнэлгийн хэрэгслийн тендер зарласан боловч амжилтгүй болсон тул хийгдээгүй байна.	0%
2.16	Гол судасны цүлхэнг судсан дотуурх аргаар эмчлэх мэс ажилбар, суулгац эмчилгээг шинээр нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийсэн мэс ажилбар, суулгац эмчилгээний тоо	Одоогоор нэвтрээгүй.	Гол судасны цүлхэнг судсан дотуурх аргаар эмчлэх мэс ажилбар, суулгац эмчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Өндөр өртөгт эм, эмнэлгийн хэрэгслийн тендер амжилтгүй болсон тул хийгдээгүй байна.	0%
2.17	Толгой хүзүүний нөхөн сэргээх мэс заслын тоог нэмэгдүүлнэ.	-	Амжилттай хийсэн нөхөн сэргээх мэс заслын тоо	2022 онд 1 удаа нөхөн сэргээх мэс засал хийгдсэн.	Нөхөн сэргээх мэс заслыг 8-с доошгүй тохиолдолд хийсэн байна.	I-IV улирал	2023 оны 11-р сарын байдлаар 15 удаагийн нөхөн сэргээх мэс засал хийгдсэн байна.	100%
2.18	Эмэгтэйчүүдийн умайн хөндийн дурангийн мэс заслыг нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийсэн умайн хөндийн дурангийн мэс заслын тоо	2022 онд 44 тохиолдол хийсэн	Эмэгтэйчүүдийн умайн хөндийн дурангийн мэс заслыг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Умайн хөндийн дурангийн мэс заслыг 2023 оны 11 сарын 17-ны байдлаар 45 удаа хийсэн байна.	100%
2.19	Хавдрын мэс засалд Эндоцинтрийг нэвтрүүлнэ.	-	Шинэ технологи ашиглан амжилттай хийсэн мэс заслын тоо	Одоогоор нэвтрээгүй.	Эндоцинтрийг хавдрын мэс засалд амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Энэ мэс засал хэрэгжүүлэх төсөл бичиж ЭМЯ-наас шалгарч БСШУЯ-ын иновацийг дэмжих сангийн шалгаруулалтанд өрсөлдөж байна.	50%
2.2	Өвдөлт намдаах эмчилгээг эхлүүлнэ.	-	Эмчилгээ хийлгэсэн хүний тоо	Өвдөлт намдаах эмчилгээг эхлүүлэх бэлтгэл ажил хангагдсан.	Өвдөлт намдаах эмчилгээг эхлүүлсэн байна.	I-IV улирал	Өвдөлт намдаах нэгжээр үйлчлүүлсэн өвчтөн - 2767, нийт 5 төрлийн ажилбар 2767 удаа хийгдсэн.	100%
2.21	Завсарлагат гемодиализ эмчилгээг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлнэ.	-	Эмчилгээ хийлгэсэн хүний тоо	Одоогоор нэвтрээгүй.	Завсарлагат гемодиализ эмчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Нийт 20 өвчтөнд 70 удаагийн эмчилгээ хийгдсэн .	100%

2.22	Нүдний лазер эмчилгээний тусламж үйлчилгээг нэвтрүүлнэ.	-	Эмчилгээ хийлгэсэн хүний тоо	Одоогоор нэвтрээгүй.	Нүдний лазер эмчилгээний тусламж үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Нүдний лазер эмчилгээ хийх бэлтгэл ажлыг хангасан.ӨМӨЗО-ны нүдний эмч нарын багтай 3 удаагийн хамтарсан үзлэг эмчилгээ хийсэн.2 эмч 1 сувилагчийг БНХАУ-ын Бээжингийн эмнэлэгт сургалтад хамруулж байна.	20%
2.23	Сувилахуйн төгсөлтийн дараах сургалт, сувилагчийн цогц чадамжийн загвар эмнэлэг болно.	Жайка, KOFIH	Сувилахуйн сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдсан тоо.	Сувилахуйн төгсөлтийн дараах сургалтын загвар эмнэлэг болох ажлын хүрээнд сувилагч, тусгай мэргэжилтний мэргэшүүлэх сургалтыг мэдрэлийн,диализ, зүрх судасны үйл оношийн сувилахуй, лаборант,дүрс оношлогооны 5 чиглэлээр нэмэгдүүлэх бэлтгэл ажлуудыг хангасан байна.	Сувилагчийн цогц чадамжийг боловсруулах ажлын хэсэгт 3 сувилахуйн мэргэжилтэн ажиллаж байна.	I-IV улирал	Төгсөлтийн дараах сургалтын загвар эмнэлэг болох зорилтын хүрээнд Сувилахуйн сургагч багш бэлтгэх сургалтыг байгууллага дээрээ авсан 3 дахь байгууллага болсон. Сувилахуйн сургагч багш бэлтгэх сургалтанд 22 сувилагч, 2 тусгай мэргэжилтэн 24 сургагч багш бэлтгэгдсэн. Төгсөлтийн дараах сургалтыг 5 чиглэлээр нэмэгдүүлэх бэлтгэл ажлуудыг ЭМС-ын 337 тоот тушаалын дагуу хийж гүйцэтгэсэн . 2024 оны 3 сараас сургалтыг 5 чиглэлээр нэмэгдүүлэх болно.	100%
2.24	"Мэдрэлийн өвчний сувилахуй" мэргэшлийн сувилахуйн хөтөлбөр боловсруулж батлуулна.	KOFIH	Хөтөлбөрт хамрагдсан хүний тоо	"Сувилахуйн сургагч багш" бэлтгэх сургалтанд мэдрэлийн сувилахуйгаар мэргэшсэн 3 сувилагч хамрагдсан байна.	Мэдрэлийн сувилахуйн мэргэшүүлэх сургалтыг 2024 оны 3 сараас шинээр нэмэгдүүлнэ.	I-IV улирал	Мэдрэлийн сувилахуйн мэргэшүүлэх сургалтын бэлтгэл ажлыг хангаж сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан ЭМХТ-д хүргүүлсэн. Ажлын байрны үнэлгээг 2024 оны 1-р улиралд хийхээр төлөвлөгөөнд тусгагдсан . Мэдрэлийн сувилахуйн сургагч багшаар 3 сувилагч бэлтгэгдсэн. Хөтөлбөр боловсруулагдаж байна.	40%
2.25	Цусны кумбсын шууд болон шууд бус /DAT, IDAT/ шинжилгээг хуруу шилний аргаар шинээр хийнэ.	-	Шинээр нэвтрүүлсэн шинжилгээнд хамрагдсан хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Цусны кумбсын шууд болон шууд бус/DAT, IDAT/ шинжилгээг хуруу шилний аргаар 20 шинжилгээ хийсэн байна.	II-IV улирал	Улаан эс in vivo иммуноглобулин, комплемент хоёрын аль нэгээр буюу хоёулангаар нь бүрхэгдсэн эсэхийг тодорхойлохын тулд кумбсын шууд шинжилгээг хийнэ. Нярайн цус задрах өвчний үед улаан эс IgG –ээр мэдрэгшсэн эсэхийг тодорхойлоход шууд кумбсын сорил чухал ач холбогдолтой. хийсэн шинжилгээ 1 Шууд бус кумбсын шинжилгээ: улаан эсийн гадаргуу дээрх эсрэгтөрөгч, in vitro эсрэгбиетэй урвалд орж байгааг 2 үе шаттайгаар тодорхойлно. Хувийн тохироо тодорхойлоход болон эсрэгбие илрүүлэхэд илүү ач холбогдолтой. Хийсэн шинжилгээний тоо 1 байна.	100%
2.26	Миелограмийн /ясны хэмийн түрхэцийн микроскоп/ шинжилгээг шинээр нэвтрүүлнэ.	-	Шинээр нэвтрүүлсэн шинжилгээнд хамрагдсан хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Ясны хэмийн микроскопын шинжилгээг амжилттай нэвтрүүлсэн байна.	III-IV улирал	Ясны хэм дэх цусны эсүүдийн тоо, харьцааг гарган лейкоз, миелома, зарим цус багадалтын оношийг тогтоож, эмчилгээний үр дүнг хянах зорилгоор хийгддэг. Хийсэн шинжилгээний тоо-1 байна.	100%

2.29	Тархины шигдээсийн эмчилгээнд бүлэн хайлуулах эмчилгээг нэвтрүүлнэ.	-	Эмчилгээ хийлгэсэн хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Тархины шигдээсийн эмчилгээнд бүлэн хайлуулах эмчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Одоогоор хийгдээгүй байгаа. Бүлэн уусгах эмчилгээг альтеплаза тариагаар хийхээр бэлтгэл байдал хангагдаад байна.	60%
2.3	Миелин задралын эмгэг G36-д дархлаа зүгшрүүлэх өндөр өртөгтэй эмчилгээг нэвтрүүлнэ.	-	Эмчилгээ хийлгэсэн хүний тоо	Одоогоор хийгдээгүй	Дархлаа зүгшрүүлэх өндөр өртөгтэй эмчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	2023 оны байдлаар дархлаа зүгшрүүлэх бай эмчилгээг тоцилизумаб, ритуксимаб, офатумаб тариаг тусламж үйлчилгээнд нэвтрүүлээд ажиллаж байна. G36 (NMOSD) оноштой 6 өвчтөнд тоцилизумаб эмчилгээ, G36 (NMOSD) оноштой 1 өвчтөнд ритуксимаб тариа, G35 (MS) оноштой 2 өвчтөнд офатумаб эмчилгээг нэвтрүүлж үр дүнг хянаж үнэлж байна.	100%

2.31	Бөөр шээсний замын чулууг уян дурангийн тусламжтай лазераар бутлах мэс засал нэвтрүүлэх. БШЗ-н хорт хавдрын мэс заслыг дурангаар авах мэс заслыг 90 хувь хүртэл хийнэ.	-	Амжилттай хийгдсэн мэс заслын тоо	2022 онд зөвхөн бөөрний хорт хавдраар 68 тохиолдолд нээлттэй болон дурангийн мэс засал хийсэн байна. Дурангийн мэс засал одоогийн байдлаар 60-70% хийгдэж байна.	Хорт хавдрын тохиолдлын мэс заслын тоог 2-3 дахин нэмэгдүүлэх, дурангийн мэс заслыг 90% хүртэл ихэсгэнэ.	I-IV улирал	2023 онд Лазерийн аппарат авахаар төлөвлөсөн боловч одоо болтол шийдэгдээгүй лазер аппарат аваагүй. 2023 онд нийт бөөрний Хорт хавдрын мэс засал 110 орсон ба үүнээс 90% орчим нь дурангаар орсон.	100%
2.32	Гуурсан хоолойг дурангийн тусламжтайгаар уушгин дах эмгэг өөрчлөлтөөс сорьц авч, оношийг баталдаг болно.	-	Гуурсан хоолойг дурангийн тусламжтайгаар онош баталгаажуулсан хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Шаардлагатай бүх тохиолдолд уушгины үрэвсэл, сүрьеэ, хавдрыг цаг алдалгүй ялган оношилж тусламж үзүүлдэг болсон байна.	I-IV улирал	Гуурсан хоолойн дуранг уушгины эмч нар хийж, одоогоор 17 хүнд төвд ойрхон хавдраас биопси авах болон гуурсан хоолойг угаасан сорьц авч, ерөнхий бактериолог болон туберкулозын микобактерийн шинжилгээнд илгээсэн байна.	100%
2.33	Цус, шээсний осмосын оношилгоог нэвтрүүлнэ.	-	Оношилгоо хийлгэсэн хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Цус, шээсний осмосын оношилгоог амжилттай нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Эрүүл мэндийг дэмжих санд төсөл бичин танилцуулаад амжилтгүй болсон. Дараа жил дахин төсөл бичиж илгээнэ.	0%
2.34	Бөөрний эдийн шинжилгээнд электрон микроскоп ашигладаг болно.	-	Электрон микроскоп ашиглан шинжилгээ хийлгэсэн хүний тоо	Одоогоор хийгдээгүй.	Бөөрний эдийн шинжилгээнд электрон микроскоп ашигладаг болсон байна.	I-IV улирал	Засгийн газарт төслийн саналыг өргөн мэдүүлсэн, энэ жилийн төсөвт ороогүй, ирэх жилийн төсөвт оруулах тухай хариу хэлсэн. Электрон микроскоп хэрхэн ажилладаг, эдийг хэрхэн бэлддэг тухай суурь ойлголтыг бөөрний эмч Жонс Холкинс их сургуульд дадлага хийх хугацаандаа танилцсан.	10%
2.35	Нурууны нугаламын үсэрхийлэлт хавдрын мэс заслын өмнөх тэжээгч судасыг бөглөх эмчилгээг хийнэ.	-	Амжилттай хийсэн эмчилгээний тоо	Одоогоор хийгдээгүй	Нурууны нугаламын үсэрхийлэлт хавдрын мэс заслын өмнөх тэжээгч судасыг бөглөх эмчилгээг амжилттай хийдэг болсон байна.	I-IV улирал	Мэдрэлийн мэс заслын тасагтай хамтран нурууны нугаламын үсэрхийлсэн хавдартай өвчтөнд эмч нарын хамтарсан үзлэг зөвөлгөө хийгдэж байна. Одоогоор нурууны нугаламын хавдарыг бөглөх эмчилгээг хийлгэх тохиолдол гараагүй байна. Элэгний анхдагч хавдараас бүсэлхий нуруунд үсэрхийлсэн тохиолдлыг мэдрэлийн мэс заслын тасаг болон дүрс оношилгооны тасагтай хамтран компьютер томографийн хяналтан дор хөлдөөх эмчилгээг шинээр нэвтрүүлэв.	100%
2.36	Томографийн хяналтан дор Ангиографийн түлэх эмчилгээг хийж эхэлнэ.	-	Амжилттай хийсэн эмчилгээний тоо	Одоогоор хийгдээгүй	Томографийн хяналтан дор Ангиографийн түлэх эмчилгээг хийж эхэлсэн байна.	I-IV улирал	Компьютер томографийн хяналтан дор уушгины үсэрхийлсэн болон анхдагч хавдраас эдийн шинжилгээ авах, хавдарыг түлэх зэрэг мэс ажилбарууд хийгдэж байна.	100%

Зорилт 3. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, аюулгүй байдлыг эрхэмлэсэн тусламж, үйлчилгээг үзүүлж, нийгмийн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх

3.1	Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	<p>Чийрэг эр хүн арга хэмжээ нь 2022 онд 3 зорилтын хүрээнд 9 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт 93 хувийн гүйцэтгэлтэй байна. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ нь 2022 онд 2 зорилтын хүрээнд 7 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Шинэ арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 90%-д хүргэсэн.</p>	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	I-IV улирал	<p>Нийгмийн эрүүл мэндийн нийт хүн амд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан. ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болох А/559 дүгээр тушаал /Эрүүл, чийрэг эр хүн/, А/760 дугаар тушаалыг /Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд/ хэрэгжүүлэн ажилласан. Эрүүл, чийрэг эр хүн арга хэмжээний хүрээнд 2023 онд 3 зорилтын хүрээнд 11 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт 95 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>	100%
3.2	Эрүүл мэндийн ажилчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	<p>Эмнэлгийн ёс зүйн салбар хороонд албан ёсоор гомдол, зөрчил бүртгэгдээгүй.</p>	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Ёс зүйн зөрчил буурсан байна.	I-IV улирал	<p>Эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд болон ажилтнуудад “Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ ба ажлын бүтээмж” сэдэвт 2 багц цагийн сургалтын удирдамжийг Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хяналтын хорооны дарга, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр батлуулан эмч, эм зүйч нарт 2023 оны 11 дүгээр сарын 10-нд зохион байгуулж 194 эмч, эм зүйч нар хамрагдсан.</p> <p>“Байгууллагын соёл”, Эмнэлгийн ажилтны харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ ба ажлын бүтээмж” сэдэвт 2 багц цагийн сургалтын сувилагч, дэмжих үйлчилгээний ажилтнуудад 2023 оны 11 дүгээр сарын 23-нд 150 сувилагч, ажилтнууд хамрагдсан.</p> <p>- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүдийн нээлттэй сонгон шалгаруулалтыг эмнэлгийн албан ёсны сайт болон фейсбүүк пейжд 2 удаа байршуулсан боловч сонгон шалгаруулалтанд материал ирээгүй.</p> <p>- Үйлчлүүлэгчээс нэр бүхий 3 эмчид ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гаргасан гомдлыг хэлэлцэн шийдвэрлэж, улирлын үр дүнгийн урамшууллыг тус тус 20% хассан.</p>	80%

3.3	Үйлчлүүлэгчид, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг авч, дүн шинжилгээ хийж, тайлагнана.	-	Сэтгэл ханамжийн хувь	Амбулаторийн үйлчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамж 85%, Хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамж 90% байсан.	Амбулаторийн үйлчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамж 88% Хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамж 93% -д хүргэсэн байна.	I-IV улирал	<p>2023 оны 1-р улиралд Судалгааг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07-р сарын 01 өдрийн А/346 тоот тушаал гарсантай холбоотойгоор эмнэлгийн байгууллага нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг байгууллагын онцлогт тааруулан боловсруулан гаргах болсонтой холбоотойгоор Улсын хоёрдугаар төв эмнэлгээс боловсруулсан асуумжийн дагуу авсан. 2023 онд “Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 457 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсан. Нэгдүгээр улиралд-120 хүн, хоёрдугаар улиралд-112 хүн, гуравдугаар улиралд-104 хүн, дөрөвдүгээр улиралд-121 хүн тус тус хамрагдсан байна.</p> <p>2023 онд “Хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 475 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсан. Нэгдүгээр улиралд-120 хүн, хоёрдугаар улиралд-112 хүн, гуравдугаар улиралд-104 хүн, дөрөвдүгээр улиралд-121 хүн тус тус хамрагдсан байна. Амбулаторийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 90.2%. Хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 91.7% байна. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр ажил сайжруулах төлөвлөгөөг боловсруулан ажилласан байна.</p>	100%
-----	---	---	-----------------------	---	---	-------------	---	------

3.4	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тохиолдох тохиолдол, үл тохирлыг цахим санд бүртгэх, дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлнэ.	-	Тохиолдол, үл тохирлын санд бүртгэгдсэн тоо, хүнд ноцтой тохиолдлын тоо	Нийт бүртгэгдсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тохиолдох тохиолдлын тоо 2018 онд 795, 2019 онд 701, 2020 онд 736, 2021 онд 765, 2022 онд 676 байсан. Ноцтой тохиолдлын тоо 2018 онд 24, 2019 онд 14, 2020 онд 3, 2021, 2022 онд тус бүр 5 бүртгэгдсэн.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тохиолдох Тохиолдол, үл тохирлын санд бүртгэгдсэн тоо буурах, хүнд ноцтой тохиолдлын тоо буурсан байна.	I-IV улирал 2023 онд нийт 939 тохиолдол бүртгэгдсэн. Тохиолдлын тоо нэмэгдсэн нь аюулгүй байдлын соёл дадлыг төлөвшүүлэх олон улсад баримталж буй бодлогод нийцүүлэн гарсан тохиолдлыг бүртгэх дадал бий болж, хэвшиж буйн илрэл юм. Бүртгэгдсэн тохиолдлуудад дүн шинжилгээ хийж дэлгэрэнгүй тайлан гарсан. Тайлангаас авч үзэхэд: Эмнэлзүйн зохицуулалтын албанаас бүртгэсэн 161 тохиолдол нь анхан шатны баримтжуулсан мэдээлэл хөтлөлт, цахим өвчний түүхийн бүрдэлттэй холбоотой тохиолдлууд байна. Халдварын сэргийлэлт хяналтын албанаас бүртгэгдсэн 109 тохиолдол нь ЭТҮХХ-ын нийт тоо бөгөөд үүнээс зохиомол амьгалын аппараттай холбоотой уушгины хатгалгаа - 49, МЗДШХ -52, ШХШЗХ-8 байна. ЭМТҮЧАБ-ын албанаас гаргасан тохиолдол бүртгэх дотоод цахим санд нийт 669 тохиолдол, үл тохирол бүртгэгдсэн. ЭМС-ын 2019 оны А/566 дугаар тушаалд заасан Кодын зэрэглэлээр ангилж үзвэл: <ul style="list-style-type: none"> • 1А буюу тохиолдол – 539 (80,6%) • 1Б буюу “Алдах дөхсөн тохиолдол”- 106 (15,9%) • 2 буюу “Таагүй тохиолдол” – 19 (2,8%) • 3 буюу “Ноцтой тохиолдол – 5 (0,7%) • “Эмнэлгийн алдаа” – 0 нотлогдсон алдаа 	100%
-----	--	---	---	---	--	---	------

3.5	Тусламж, үйлчилгээ үзүүлэхэд тохиолдох эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ хийх, дүн шинжилгээ хийх, эрсдэлийн хариу арга хэмжээ авна.	-	Арилгасан эрсдэлийн тоо	2022 онд нийт 175 эрсдэл тодорхойлсон. Эрсдэлийн 7 чиглэлээс тоног төхөөрөмжтэй холбоотой эрсдэл 25% буюу давамгайлж байсан. Эрсдэлийн хариу арга хэмжээний дараа ноцтой эрсдэл 5%-иар, өндөр эрсдэл 42%-иар буурсан.	Эрсдэлийн хариу арга хэмжээ авснаар ноцтой, өндөр эрсдэлүүд 8-10 хувиар буурсан байна.	I-IV улирал	2023 онд нийт 139 эрсдэл тодорхойлсон. УХТЭмнэлгийн гарч болох эрсдэлийн жагсаалтыг 7 чиглэлээр гарган ажиллаж байна. 1.Удирдлага менежмент, зохион байгуулалттай холбоотой-5 буюу 3.5% 2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой-16 буюу 11.5% 3.Тоног төхөөрөмжтэй холбоотой-44 буюу 31.6% 4.Барилга байгууламжтай холбоотой-29 буюу 20.8% 5.Хүний нөөц, мэргэшлийн чадвартай холбоотой-28 буюу 20.1% 6.Халдварын сэргийлэлт хяналттай холбоотой-13 буюу 9.3% 7.Бусад-4 буюу 2.8% нийт 139 гарч болох эрсдэлийг тодорхойлсон байна. Нийт бүртгэгдсэн 139 эрсдэлээс эрсдэлийн удирдлагын өмнө 1.Бага эрсдэл 0% 2.Дунд эрсдэл 20 буюу 14.4% 3.Өндөр эрсдэл 27 буюу 19.4% 4.Ноцтой эрсдэл 92 буюу 66.1% тус тус байсан бол эрсдэлийн удирдлагын дараа ноцтой эрсдэл 70 буюу 76 хувиар, өндөр эрсдэл 20 буюу 74 хувиар тус тус бууруулсан байна.	100%
3.6	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын дотоод хяналтын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулна.	-	Хэрэгжилтийн хувь	2022 онд Дотоод хяналт хийх нэгдсэн хөтөлбөрийг 15 чиглэлээр хийхээр батлуулж 14 удаа хийгдсэн. Нийт 147 үл тохирол үл тохирол илэрч залруулах арга хэмжээ авч, 85 зөвлөмж өгсөн.	Дотоод хяналтын тоо нэмэгдсэн байх	I-IV улирал	ISO 9001:2015 стандартын шаардлагад нийцүүлэн чанарын менежментийн тогтолцооны суурь 5 журмын нэг болох Дотоод аудит хийх тухай журмыг мөрдөн ажилласан. Эмнэлгийн Ерөнхий захирлын 2022 оны 07 дугаар сарын 1-ний өдрийн А/69 дугаар тушаалаар “Дотоод аудитын журам” УХТЭ-БМ-06 ЧМТЖ 4:2022-5 журмыг шинэчлэн батлуулсан. 2023 онд Дотоод аудитын нэгдсэн хөтөлбөрийг 15 чиглэлээр хийхээр батлуулж нийт 18 удаа аудит хийсэн. Дотоод аудитаар нийт 258 үл тохирол илэрснээс 60 орчим үл тохирлыг газар дээр нь залруулах арга хэмжээ авч залруулсан бөгөөд бусад илэрсэн үл тохирлыг 7-14 хоногийн дараа залруулалтын тайлангийн дагуу дахин хянасан. Нийт 154 зөвлөмж өгсөн. Түүнчлэн тасаг нэгжүүдийн чанарын багууд дотоод хяналт хийх хуваарийн дагуу тогтмол хяналт хийсэн.	100%

3.7	Ариутгал халдваргүйтгэлийн тасаг, Цөмийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагаанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог MNS ISO 45001 : 2018 хэрэгжүүлнэ.	-	Стандартын хэрэгжилтийн хувь	Одоогоор хийгдээгүй	MNS ISO 45001 : 2018 стандартыг мөрдөн ажилласан байна.	I-IV улирал	Ариутгал халдваргүйтгэлийн тасаг, Цөмийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагаанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог MNS ISO 45001 : 2018 хэрэгжүүлэх ажлы хүрээнд Стандарт хэмжил зүйн төвөөс 140,000 төгрөгөөр холбогдох стандартыг худалдан авсан. Стандарт хэмжил зүйн үндэсний төвөөс 15 эрүүл мэнийн ажилтанд сургалт авахаар төлөвлөсөн. Сургалтын төлбөр 1,350,000 төгрөгийг Дэмжих сангийн төслийн үлдэгдэл мөнгөнөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн.	100%
3.8	MTCA (метициллинд тэсвэртэй стафилокок аурис)-ын илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, халдварын сэргийлэлт сэдвээр багц цагийн сургалт зохион байгуулна	-	Сургалтанд хамрагдсан хүний тоо	"Олон эмэнд тэсвэржсэн бичил биетний халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авах" сэдвээр 25 эмчид 2022 оны 8 дугаар сарын 26-нд Солонгос улсын KOFIN төслийн санхүүжилтээр танхимийн сургалт зохион байгуулсан.	MTCA (метициллинд тэсвэртэй стафилокок аурис)-ын илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, халдварын сэргийлэлт сэдвээр багц цагийн сургалт зохион байгуулсан байна.	I-IV улирал	Зүрх судасны тасаг MTCA иргэдэд болон эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан зөвлөмж гаргасан. УСТ-аас сүрьеэгийн халдвараас сэргийлэх зөвлөмж гаргаж 2023 оны 3 дугаар сарын 24-нд зохион байгуулагдсан өдөрлөгийн үеэр үйлчлүүлэгчид тарааж мэдээлэл өгсөн. Ерөнхий мэс засал судлалын тасгаас Олон эмэнд тэсвэртэй сэрэмжлүүлэх бичил биетний халдварын сэргийлэлт, хяналт тусгаарлан сэргийлэлтийн талаар амьсгал, агаар дусал, хавьтлын халдварын үед авах арга хэмжээ сэдэвт 3 төрлийн санамж, зөвлөмж, тэмдэг тэмдэглээ хийж тасгуудад тараасан. "ОЭТББ-ний халдварын сэргийлэлт хяналт, MTCA-аар үүсгэгдсэн халдварын илрүүлэг деколонизаци" сэдвээр 2023 оны 2 сарын 07-ны өдөр 175 сувилагч тусгай мэргэжилтэнг хамруулан сургалт зохион байгуулсан. Эм зүй хангамжийн албатай хамтран 2023 оны 11 сарын 01-нд 1 багц цагийн сургалт зохион байгуулагдсан.	100%
Зорилт 4. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажилтаны сэтгэл ханамж тогтвортой байдлыг бэхжүүлэх								
4.1	Ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт 90%-д хүрсэн.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	I-IV улирал	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт 90%-д хүрсэн.	90%

4.2	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна.		Шинээр батлагдсан албан тушаалын тодорхойлолтын хувь	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу нийт 144 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан	Эмнэлгийн 50 мэргэжилтэн, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан байна.	I-IV улирал	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу Захиргаа, хүний нөөцийн албаны 5, Мэдээллийн технологийн албаны 2, Ариутгал халдваргүйтгэлийн тасгийн 7, Тусгай тасгийн 7, Инженерийн байгууламжийн албаны 11, нийт 5 алба, тасгийн 32 албан тушаал, 58 мэргэжилтэн, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан. (Ерөнхий захирлын 2023 оны А/34, А/38, А/43, А/46, А/52 дугаар тушаал)	100%
4.3	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу эмнэлгийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулна.	-	Хөдөлмөрийн гэрээ шинэчлэн байгуулсан хувь	Шинэчлэн баталсан Хөдөлмөрийн дотоод журмын дагуу эмнэлгийн удирдах ажилтан, хэсэг, тасаг, албадын батлагдсан 566 орон тооноос 43 тушаалтантай "Хөдөлмөрийн гэрээ" шинээр болон шинэчлэн байгуулсан.	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу батлагдсан орон тооноос 523 ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан байна.	I-IV улирал	Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нийт 566 шинээр орсон болон ажилтнуудтай нэг бүрчлэн "Хөдөлмөрийн гэрээ" шинэчлэн байгуулсан.	100%
4.4	"Эмнэлэгт эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанг сонгон шалгаруулж ажилд авах журам" шинэчлэн батална.	-	Шинэчлэгдэн батлуулсан журам	Эмнэлгийн даргын 2014 оны 168 дугаар тушаалаар батлагдсан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанг сонгон шалгаруулж ажилд авах журмыг мөрдөн ажиллаж байна.	Журмыг шинэчлэн захирлаар батлуулсан байна.	II улирал	Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын А/31 дүгээр тушаалаар "Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж, ажилд авах журам" шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна.	100%
4.5	Сул ажлын байрыг ил тод сонгон шалгаруулж нөхнө.	-	Нөхсөн сул ажлын байрны тоо	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн "Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан" програмд ажлын байрны зар тогтмол оруулж байна.	Сул орон тоог бүрэн нөхсөн байна.	I-IV улирал	2023 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар нийт 54 ажлын байранд давхардсан тоогоор 139 удаа сонгон шалгаруулах зарыг эмнэлгийн вэб хуудас, эмнэлгийн фейсбүүк фейжд ил тод байршуулсан. 2023 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар нийт 143 ажилтныг сонгон шалгаруулж шинээр ажилд авсан. Үүнээс 33 эмч, 55 сувилагч, туслах сувилагч, 24 үйлчлэгч, 31 бусад ажилтнууд байна.	100%

4.6	"Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам"-ыг шинэчлэн батлах	-	Шинэчлэгдэн батлуулсан журам	Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны 4 дүгээр сарын 10-ны А/38 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх тухай" журмыг мөрдөн ажилласан.	"Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журам"-ыг шинэчлэн захирлаар батлуулсан байна.	II улирал	"Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, "Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 02 дугаар зөвлөмж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 албан даалгаврын биелэлтийг хангах, эмнэлгийн алба, төв, тасаг, хэсгийн дарга эрхлэгчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх нэгдсэн арга, аргачлалаар хангах удирдах албан тушаалтны ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор алба, төв, тасаг, хэсгийн удирдах албан тушаалтнуудын ажлын үр дүнгийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг Ерөнхий захирлын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/60 дугаар тушаалаар батлан, мөрдөн ажиллав.	100%
4.7	Архивын улсын үзлэгт хамрагдана.	-	Улсын үзлэгийн дүн	Үндэсний Архивын хяналт шалгалтанд 2020 онд орж эмнэлгийн архивын үйл ажиллагаанд 90 оноо авсан. Архивын улсын үзлэгт 2015 онд орж 96 онооны үнэлгээ авсан.	Архивын улсын үзлэгт хамрагдан амжилттай дүн үзүүлсэн байна.	I-II улирал	Эмнэлгийн угаалгын хэсгийн 1 давхарт 3 ерөөнөөс бүрдсэн эмнэлгийн архивын ерөөг шинээр засварлах ажлыг инженерийн байгууламжийн албатай хамтран хийж байна. Эмнэлгийн ерөнхий захирлын баталсан 2022 оны тушаалуудыг сканнердан цахим архив үүсгэсэн. Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/36 дугаар тушаалаар "Эмнэлгийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам", Ерөнхий захирлын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/37 дугаар тушаалаар, "Эмнэлгийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх журам" тус тус баталж, мөрдөн ажилласан.	100%

4.8	Тусламж үйлчилгээний тэргүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнгүүдэд зориулж тогтмол сургалтанд хамруулна.	-	Сургалтанд хамрагдсан хүний тоо	Одоогоор суралцсан ажилтан байхгүй.	Улирал бүр 10-аас доошгүй хүн сургалтанд хамруулдаг болсон байна.	I-IV улирал	<ul style="list-style-type: none"> Гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх урт хугацааны сургалтанд нийт 5 улсад, 13 мэргэжлийн чиглэлээр 16 эмч, 1 сувилагч, 1 рентген техникч нийт 17 эмнэлгийн мэргэжилтнүүд ганцаарчилсан болон багаар хамрагдан суралцсан. Үүнд: бөөрний мэс заслын чиглэлээр 2 эмч АНУ болон Япон улсад, нүдний пластик мэс заслын чиглэлээр 1 эмч Япон улсад, Бөөр судлал чиглэлээр 1 эмч АНУ, тархи нугасны хавдрын чиглэлээр 1 эмч БНСУ-д, хавдрын чиглэлээр 1 эмч Тайваньд, уушги судлал чиглэлээр 1 эмч БНСУ-д, Мэдрэлийн мэс заслын мэдээгүйжүүлгийн чиглэлээр 1 эмч Тайваньд, зүрхний мэдээгүйжүүлгийн чиглэлээр 1 эмч Тайваньд, мэдрэлийн мэс засал чиглэлээр 1 эмч БНСУ-д, гар сарвууны мэс засал чиглэлээр 1 эмч БНСУ-д, Зүрхний судсан дотуурх оношилгоо эмчилгээний чиглэлээр 2 эмч, 1 сувилагч, 1 рентген техникч БНСУ-д, нүд судлал чиглэлээр 2 эмч БНХАУ-ын ӨМӨЗО-нд, ходоодны уян дурангийн чиглэлээр 1 эмч Япон улсад тус суралцсан байна. 	100%
4.9	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгээ дотоодын болон гадаадын IF бүхий (зэрэглэл өндөртэй) сэтгүүлд хэвлүүлж, ОУ-ын ЭШХ-д хэлэлцүүлнэ	-	Сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллийн тоо, хэлэлцүүлсэн илтгэлийн тоо	Дотоодын сэтгүүлд 12, эмнэлгийн эрдэм шинжилгээний хурлын номонд 133, гадаадын сэтгүүлд 4 өгүүлэл нийтэлсэн. Олон улсын эрдэм шинжлэлгээний хуралд 6 илтгэл хэлэлцүүлсэн	Дотоодын сэтгүүлд 15-аас дээш, гадаадын зэрэглэл өндөртэй сэтгүүлд 1-ээс дээш өгүүлэл нийтлүүлж, Олон улсын эрдэм шинжилгээний хуралд 4-өөс дээш илтгэл хэлэлцүүлсэн байна.	I-IV-р улирал	Нийт дотоодын сэтгүүл, хуралд 32 өгүүлэл, илтгэл хэлэлцүүлсэн. Гадаадын сэтгүүлд 1, гадны олон улсын эрдэм шинжилгээний хуралд 11 илтгэл хэлэлцүүлсэн. (Урологи, Нлаб, ХБЭСТ, ЦОЭТ, ЗСТ, МЭЭТ, БДШСТ)	100%
4.1	Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.	-	Хурлын тоо	Нийт 3 удаа хурал 2022 онд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан.	Жилд 3-аас доошгүй удаа эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан байна.	III-р улирал	Резидент эмч нарын Эрдэм шинжилгээний хурал, мөн Эрдмийн Чуулган-45 зохион байгуулж эмч, сувилагч нар нийтээрээ оролцсон	100%

Зорилт 5. Байгууллагын дэд бүтэц, цахим мэдээлэлийн тогтолцоог сайжруулах

5.1	Цахим гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлнэ.	-	Цахим гарын үсэг тогтмол хэрэглэдэг эмчийн хувь	Одоогоор нэвтрээгүй.	Цахим гарын үсгийг бүх эмч нар хэрэглэдэг болсон байна.	I-IV улирал	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж байгаатай холбоотой байгууллагын ажилтнуудад ажлын байр дээр ирж тоон гарын үсэг үүсгэх үйл ажиллагааг эмнэлгийн захиргаанаас 2022 оны 05 дугаар сарын сарын 30,31-ний өдрүүдэд Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн байцаагчтай хамтарч 302 ажилтан, 2023 оны 03 сарын 10-ны өдөр Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн байцаагчтай хамтарч 190 ажилтан, нийт 492 ажилтныг цахим гарын үсэгтэй болгосон. Эмнэлгийн мэдээллийн систем болох Карте системд хэрэглэх холболтууд хийгдсэн.	90%
5.2	Урсгал их засварын ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.	-	Гүйцэтгэлийн хувь	Одоогоор хийгдээгүй.	Төлөвлөсөн засварын ажил бүрэн хэрэгжсэн байна.	I-IV улирал	2023 оны жилийн эцсийн байдлаар 38 ажил төлөвлөгдсөнөөс 34 ажил хийгдэж 90 % биелэлттэй байна.	90%
5.3	Төв байрны дээвэр гадна фасадны засварын зураг төсвийг батлуулна.	-	Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ	Одоогоор хийгдээгүй.	Зураг төсөв батлагдсан байна.	I-IV улирал	2023 онд зураг хийх төсөв батлагдаагүй.	0%
5.4	Төв байр болон 50 орт байрны цахилгааны ерөнхий шитийг шинэчлэн солих засварын ажлын зураг төсвийг хийлгэнэ.	-	Батлагдсан зураг төсөв	Одоогоор хийгдээгүй.	Зураг төсөв батлагдсан байна.	I-IV улирал	50 орт байрны засварын зураг төсөв хийж ЭМЯ-д хүргүүлсэн боловч батлагдаагүй тул 2024 оны төсөвт дахин суулгана.2023 онд 1.5 тэрбум төгрөг батлагдсан.2024 онд засвар хийгдэж эхлэнэ.	20%
5.5	Эмч хөгжлийн төвийг ашиглалтанд оруулна.	-	Гүйцэтгэлийн хувь	Эмч хөгжлийн төвийг ашиглалтанд оруулах ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна.	Улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтанд оруулсан байна.	I-IV улирал	Эмч хөгжлийн төвийн барилгын ажлын явц 80% гүйцэтгэлтэй байна.	80%
5.6	Эмнэлгийн хашаан дотор гадна гэрэлтүүлгийг цогцоор нь сайжруулна.	-	Гүйцэтгэлийн хувь	Эмнэлгийн хашаан дотор гадна гэрэлтүүлгүүдийг 80 хувьтай ашиглаж байна.	Бүх гэрэлтүүлгийг ажилладаг болгосон байна.	I-IV улирал	Цогцоор нь сайжруулж чадаагүй боловч хэсэгчилж сайжруулсан.	15%
5.7	Эмнэлгийн орчин дахь хяналтын камерын хүрэлцээг сайжруулна.	-	Шинээр суурилуулсан хяналтын камерын тоо	Эмнэлгийн орчин дах хяналтын камерын шинэчлэл 80 хувьтай байна.	Гадна талбайн хэсэгт хяналтын камерыг шинэчилж хүрэлцээг сайжруулсан байна.	I-IV улирал	Эмнэлгийн гадна талбайн 5 ширхэг камер, 68ш дотуур камер шинээр суурилуулсан. хорт эмийн хяналт, дотор талбайн хяналтыг сайжруулсан. Эмнэлгийн хэмжээнд шинээр 73 ширхэг хяналтын камер суурилуулав.	100%

5.8	Сувилахуйн ур чадварын сургалтын өрөөг тохижуулж жишиг болгоно.	Жайка, KOFIN	Гүйцэтгэлийн хувь	Гүйцэтгэл 100 % -н биелэлттэй байна.	Сувилахуйн дадлага сургалтууд 4 чиглэлээр төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан. Мөн шинэ сувилагч нарын ур чадварын сургалтуудыг төлөвлөгөөний дагуу 4 удаа зохион байгуулсан.	I-VI сард	Сувилахуйн ур чадварын өрөөг Улаан загалмайн нийгэмлэгийн дэмжлэгтэй бүрэн засварлан тохижуулж сургалтын зориулалттай 30 сандал, 2 шкаф, яаралтай тусламжийн самбаруудаар тохижилт хийгдсэн.	100%
5.9	ABLE программыг албан бичиг хөтлөлтөд бүрэн нэвтрүүлнэ.	-	Бүрэн цахимжсан албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа	Үйл ажиллагаа жигдэрсэн. Программтай холбоотой бүх сургалтыг авч дууссан.	Байгууллагын албан бичиг хөтлөлт бүрэн цахимжсан байна.	I-IV улирал	ABLE программыг албан бичиг хөтлөлтөд бүрэн нэвтрүүлсэн. Байгууллагын удирдах албан тушаалтнууд бүгд өдөр тутмын үйл ажиллагаандаа албан бичиг хөтлөлтийн ABLE системийг хэрэглэдэг.	100%
5.1	Эмнэлгийн Аксис карте программыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн систем болох WHONET программтай холбоно.	-	Гүйцэтгэлийн хувь	Одоогоор хийгдээгүй.	Эмнэлгийн Аксис карте программыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн систем болох WHONET программтай холбож 2 системд мэдээлэл ижил ордог болсон байна.	I-IV улирал	Whonet программтай холболт хийгдсэн. Эмнэлгийн мэдээллийн системээс эмгэг төөрөгч үүсгэгч илэрсэн шинжилгээний хариуг WHONet программ руу илгээх боломжтой болсон.	100%
Зорилт 6. Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах								
6.1	Авилга ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөсөн арга хэмжээний биелэлтийн хувь	Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, тайланг зурган хавсралтын хамт Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	I-IV улирал	Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, тайланг Эрүүл мэндийн яаманд 2023 оны 06 дугаар сард, 2023 оны 12 дугаар сард тус тус хүргүүлсэн.	100%
6.2	"Эмнэлгийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах журам" боловсруулан батлах	-	Батлагдсан журам	2011 оны "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хуулийг даган мөрдсөн.	Журмыг боловсруулан захирлаар батлуулсан байна.	I улирал	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/396 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/28 дугаар тушаалаар "Мэдээллийн ил тод байдлыг хангах журам" батлан, мөрдөн ажилласан.	100%
6.3	Байгууллагын санхүүгийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлж өр авлагагүй ажиллана.	-	Өр авлагын хэмжээ	Өрийн хэмжээ 2022 онд 2,790,140,000 төгрөг байна. Авлагын хэмжээ 2022 онд 1,812,545,837 төгрөг байна.	Байгууллагын санхүүгийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлж өр авлагагүй ажилласан байна.	I-IV улирал	Өрийн хэмжээ 2023 оны 11 сарын байдлаар 6,314,836,331 төгрөг байна. Авлагын хэмжээ 5,205,165,414 төгрөг байна.	80%

6.4	Байгууллагын үйлчилгээний соёлын заавар/удирдамжийг боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ.	-	Батлагдсан байгууллагын удирдамж/заавар, байгууллагын соёлтой холбоотой гарсан санал гомдол	Одоогоор хэрэгжүүлээгүй.	Байгууллагын үйлчилгээний соёлын заавар, удирдамжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн А/42 дугаар тушаалаар "Улсын хоёрдугаар төв эмнэлгээр үйлчлүүлэх журам" УХТЭ-БМ-06 ТҮЖ 25:2023-1 журмыг боловсруулан батлан, мөрдөж ажиллаж байна. Энэхүү журамд үйлчлүүлэгчийн үүрэг хариуцлага, эмнэлгийн ажилтны үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан. Үйлчлүүлэгчийн цаг товлох, үйлчилгээ авах үйл явцын зураглал, үйлчлүүлэгч амбулаторийн тусламж, үйлчилгээ авах үйл явцын зураглал, үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэх үйл явцын зураглалыг боловсруулан, өвчний түүх нээх цэгт болон амбулаторийн давхар бүрт үйлчлүүлэгчийн нүдэнд ил харагдахуйц байрлуулсан.	100%
6.5	Эмнэлзүйн удирдамж, зааврыг шинэчлэх, шинээр боловсруулж батлуулна.	-	Батлагдсан байгууллагын удирдамж/заавар, байгууллагын соёлтой холбоотой гарсан санал гомдол	Эмнэлгийн бүх төрлийн тусламж, үйлчилгээнд удирдамж, заавар боловсруулан ажилласан.	Эмнэлзүйн 20 заавар, удирдамжийг шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	I-IV улирал	Манай алба нь удирдамж боловсруулахгүй ЭМД,ЭМЯ,ЭМДҮЗ-с гаргасан тогтоол, тушаалын дагуу ажиллаж байна.	100%
6.6	Эмнэлзүйн стандартыг шинэчлэн боловруулж холбогдох байгууллагад хүргүүлнэ.	-	Шинээр боловсруулсан стандартын тоо	Эмнэлгийн бүх төрлийн тусламж, үйлчилгээнд стандартыг боловсруулан ажилласан.	Нийт 31 стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	I-IV улирал	Манай алба нь удирдамж боловсруулахгүй ЭМД,ЭМЯ,ЭМДҮЗ-с гаргасан тогтоол, тушаалын дагуу ажиллаж байна.	100%

Жич: Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан өөрийн эмнэлгийн чиг үүрэгт хамааралтай арга хэмжээнүүдийг тусгасан болно.Үүнд:

Монгол Улсын Загсийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2023 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ (ЗГҮАХ: Засгийн Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2022 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ (МУТЖҮ: Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл)

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө

Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд 2023 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ (БДХСтратеги.Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөө)

2023 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд нийт 76 ажил төлөвлөсөн.

Үүнд:

Шинээр төлөвлөсөн 25 ажил

Тогтмолжуулж нэмэгдүүлэх 20 ажил

Тогтмол зохихон байгуулдаг 31 ажил байгаа болно